



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар A/39

Улаанбаатар хот

┌ Үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн ┐
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоол, Газрын дүрмийн 7.1.1, Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Албан хаагчдын цалингийн хэмжээг хавсралтад заасан хувь хэмжээгээр тооцож 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2023 оны A/03, A/17 дугаар тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ